

НИЙГЭМ СУДЛАЛ VIII

Бие даан суралцах ажлын дэвтэр

Суралцахуйн зураглалтай
ажиллах алхам:



- I алхам: Багшийн зөвлөсөн дасгал, даалгавруудаас эхлэн ажиллаарай.
- II алхам: Өөрийн хийж чаддаг болсон дасгал, даалгавруудыг тохирох түвшний өнгөөр будаарай.
- III алхам: Тухайн бүлгийн дасгал, даалагаврыг гүйцэтгэж эхэлсэн болон дуусгасан хугацааг заавал тэмдэглээрэй.
- IV алхам: Дасгал, даалгаврыг гүйцэтгэсний дараа өөрийгөө үнэлээрэй.
- V алхам: Багшаараа үнэлүүлж, өгсөн зөвлөмжийн дагуу сайжруулаарай.

Бүлэг	7-р анги III түвшин			8-р анги III түвшин				9-р анги III түвшин			
Хувь хүн ба нийгэм	7.3a	7.3b	7.3c	8.3a	8.3b	8.3c		9.3a	9.3b		
Хувь хүн ба соёл	7.3a	7.3b	7.3c	8.3a	8.3b	8.3c	8.3г	9.3a	9.3b	9.3в	9.3г
Хувь хүн ба эдийн засаг	7.3a	7.3b	7.3c	8.3a	8.3b	8.3c	8.3д	9.3a	9.3b	9.3в	
Эхэлсэн хугацаа											
Дууссан хугацаа											
Өөрийн үнэлгээ											
Багшийн үнэлгээ											

Бүлэг	7-р анги II түвшин			8-р анги II түвшин					9-р анги II түвшин				
Хувь хүн ба нийгэм	7.2a	7.2b	7.2c	8.2a	8.2b	8.2в	8.2г	8.2д		9.2a	9.2b	9.2в	9.2г
Хувь хүн ба соёл	7.2a	7.2b	7.2c	8.2a	8.2b	8.2в	8.2г	8.2д	8.2е	8.2в	9.2a	9.2b	9.2г
Хувь хүн ба эдийн засаг	7.1a	7.1b	7.1в	7.1г	8.2a	8.2b	8.2в	8.2г	8.2д	8.2е	9.2a	9.2b	9.2г
Эхэлсэн хугацаа													
Дууссан хугацаа													
Өөрийн үнэлгээ													
Багшийн үнэлгээ													

Бүлэг	7-р анги I түвшин			8-р анги I түвшин							9-р анги I түвшин												
Хувь хүн ба нийгэм	7.1a	7.1b	7.1в	8.1a	8.1b	8.1в	8.1г	8.1д	8.1е	8.1ж	8.1з	8.1и	8.1к	9.1a	9.1b	9.1в	9.1г	9.1д	9.1е	9.1е	9.1ж	9.1з	
Хувь хүн ба соёл	7.1a	7.1b	7.1в	8.1a	8.1b	8.1в	8.1г	8.1д	8.1е	8.1е	8.1ж	8.1з		9.1a	9.1b	9.1в	9.1г	9.1д					
Хувь хүн ба эдийн засаг	7.1a	7.1b	7.1в	7.1г	7.1д	7.1е	7.1е	8.1a	8.1b	8.1в	8.1г	8.1д	8.1е	8.1е	8.1ж	8.1з	8.1и	8.1к	9.1a	9.1b	9.1в	9.1г	9.1д
Эхэлсэн хугацаа																							
Дууссан хугацаа																							
Өөрийн үнэлгээ																							
Багшийн үнэлгээ																							



Бүлэг: **Хувь хүн ба нийгэм**
Сурагчийн овог, нэр:.....

Эхэлсэн.... он.....сар.....өдөр....цаг
Дууссан.... он.....сар.....өдөр....цаг

I	II	III
---	----	-----

8.1а. Сурагч та өөр орон нутаг амьдарч буй найздаа ил захидал илгээх гэвэл, хаанаас энэхүү захидлаа илгээж байгаагаа мэдээлээрэй.

Хэнээс:
Хаанаас: хот, аймаг
..... дүүрэг, сум баг
... гудамж, байр
тоотоос илгээв.


8.1б. Танай орон нутагт чиний харьяалагддаг ямар бүлгүүд болон ямар ямар байгууллага байгааг жагсаан бичээрэй. Жуулчдад зориулан орон нутгийнхаа байгууллагуудын байршлыг харуулсан зураглал хийнэ үү.

Бүлгүүд:

Байгууллагууд:

Зураглал:

8.1в. Доорх гурвалжинд эрдэмтэн А.Маслоугийн тодорхойлсон “Хүний хэрэгцээний шатлал”-ыг зөв дарааллаар байрлуулаарай.



8.1г. Танай орон нутгийн хүмүүсийн амьдралын дараах хэрэгцээг ямар байгууллага, бүлгүүд хангадаг вэ? Нэрлэж бичээрэй.

- Мөнгө санхүүгийн хэрэгцээ
- Сурч, боловсрох хэрэгцээ
- Аюулгүй байдлын хэрэгцээ
- Өөрийгөө илэрхийлэх хэрэгцээ
- Бие физиологийн хэрэгцээ
- Хүндлэл хүлээх хэрэгцээ

8.2a. Мэдээллийг уншиж шинжлээд, асуултад хариулаарай.

Монголын Шинжлэх ухааны академийн Философи, социологи, эрхийн хүрээлэнгийн судлаачид нийгмийн бүлгүүдийн харилцаанд гарч буй өөрчлөлтийн талаар судлан үзэхдээ хот, суурин газрын хүмүүс хоорондын харилцаанд ойр дотно, нөхөрсөг байдал хэрхэн өөрчлөгдөж буй талаар дараах судалгааны дүнг танилцуулсан байна.

Хот, суурин газрын хүмүүсийн харилцааны дотно нөхөрсөг байдал,

	1990	2012	Өөрчлөлт
Анхдагч бүлгийн харилцаа	51.7	44.1	-7.6
• Хамаатан садан, ураг төрлийн барилдлагатай хүмүүс	33.8	27.7	-6.1
• Нэг нутаг усны хүмүүс	13.6	7.3	-6.3
• Нэг орц, хашаа, гудамжны хүмүүсийн харилцаа	4.3	9.1	4.8
Хоёрдогч бүлгийн харилцаа	41.5	55.7	14.2
• Нэг хүсэл сонирхолтой (үзэл бодолтой) хүмүүс	13.6	13.2	-0.4
• Нэг ажлын газар (тасаг, салбар)-ын хамт олон	17.6	19.9	2.3
• Нэг анги, нэг он (цэрэг)- зэрэг бүлгийн гишүүд	7.9	13.6	5.7
• Адил хөрөнгө чинээтэй хүмүүс	2.4	9.0	6.6

Асуулт: Хоёрдогч бүлгийн харилцаанд гарч буй өөрчлөлтийн өсөлт, бууралтыг анхдагч бүлгийн харилцааны өөрчлөлтийн өсөлт, бууралттай харьцуулан бичнэ үү. Өөрчлөлтүүдийн шалтгаан нь юу байж болох вэ?

.....

.....

.....

8.2б. Тохиолдлыг шинжлээрэй.

“Нийгэм судлал VIII” сурах бичгийн 17 дахь талаас Тохиолдол 1, 2-ыг уншаад, доорх асуултын дагуу дүн шинжилгээ хийгээрэй.



Сурах бичгийг дараах QR кодоор орж ашиглана уу!

а) Асуудал үүссэн үндсэн болон нийтлэг шалтгаан нь юу байна вэ?

.....

.....

б) Үүссэн асуудлуудыг шийдвэрлэхгүй бол тухайн орон нутагт цаашид ямар үр дагавар гарч болзошгүй вэ? Олон талаас нь харж тайлбар бичнэ үү.

.....

.....

в) Танай орон нутагт дээрх тохиолдлуудтай төстэй, хүмүүсийн нийгмийн байр суурь, эрх ашгийн ялгаатай байдлаас үүдэлтэй ямар асуудлууд бий болсон бэ? Жагсаан бичээрэй.

.....

.....

8.1ё. Зохисгүй хэрэглээ, буруу хэвшил, гэмт хэрэг, шударга бус байдал, авилга, байгаль орчинтой зүй бусаар харилцахыг ... гэнэ. Зөв хариултыг сонгоорой.

А. Соёлын өөрчлөлт Б. Соёлын хожимдол В. Соёлын өөрчлөлт Г. Соёлын нэвчилт

8.1ж. Соёлын хожимдлын жишээг өнгөөр ялган будаарай.

Гадаадад цагаачлах, цахим тоглоомд донтох, байгалийн гамшигт үзэгдэлд нэрвэгдэх, уул овоо тахиx, цахимаар харилцахдаа зүй бус үг хэрэглэх, машин шүтлэг, угсаа гарвалаар нь ялгаварлан хандах

8.1з. Соёлын өөрчлөлтөд нөлөөлөх хүчин зүйлсийн жишээг сонгоно уу.


байгалийн гамшиг, цаг уурын өөрчлөлт, цахим тоглоомд донтох, уул овоо тахиx, япон улсын оюутнууд монголд амьдрах, машин шүтлэг, угсаа гарвалаар нь ялгаварлан хандах, ХХ зуунд компьютер бүтээв.

Өөрийгөө үнэлээрэй.

2 од хэсэгт гүйцэтгэсэн даалгавар бүрээс сайн ойлгосон, мэдсэн, чадсан даалгаврын харгалзах дугаарыг, 1 хүсэл хэсэгт дутуу ойлгосон, ойлгоогүй, дэмжлэг шаардлагатай даалгаврын харгалзах дугаарыг тус тус бичнэ үү.

★ ★ Хоёр од	👨‍🎓 Нэг хүсэл	👩‍🏫 Багшийн тэмдэглэл

8.2а. Соёл, материаллаг соёл, оюуны соёл гэсэн ойлголтуудын хамаарлыг зөв үзүүлсэн бүдүүвч аль нь вэ? Сонгосон бүдүүвчийнхээ дагуу тайлбар бичнэ үү.



8.2б. Танай орон нутгийн гол бахархал болсон соёлын үнэт зүйл юу вэ? Ямар шалгуурын үүднээс хамгийн гол бахархал хэмээн үзэж байгаагаа бичнэ үү.

8.2в. Зөв утгыг холбож, албан ба албан бус хэм хэмжээний ялгаатай болон төсөөтэй шинжийг харьцуулан бичээрэй.

Албан бус хэм хэмжээ	Зан заншил, ёс суртахуун
Албан хэм хэмжээ	Хууль, дүрэм

8.2г. Орон нутгийнхаа өв соёлыг хайрлан хамгаалахад албан болон албан бус ямар хэм хэмжээг танай орон нутагт дагаж мөрддөг вэ? Жишээ гаргаж, хүснэгтээр харуулна уу.

8.2д. Тохиолдол шинжлээрэй.

Дараах QR кодоор нэвтэрч VIII анги “Бусдын соёлыг ойлгож, хэрхэн хүндэтгэлтэй хандах вэ?” сэдэвт хичээлийг үзээрэй. Оюутан Б, 3 нарт юу тохиолдсонтой танилцан, дараах асуултын дагуу дүн шинжилгээ хийнэ үү.



а) Тохиолдол ямар нөхцөл байдлыг илэрхийлж байна вэ?

б) Дээрх нөхцөл байдал ямар шалтгаанаас болж үүссэн бэ?

в) Б, 3 нарын ангийн оюутнууд тэдэнтэй харилцахдаа ямар алдаа гаргасан бэ?

г) Тохиолдолд орон нутгийн соёлын ялгаатай байдал хэрхэн илэрч байна вэ?

8.2е. Таны бодлоор соёлын хожимдол гэсэн ойлголт аль зурагт холбогдох вэ? Яагаад?



8.2ё. “Соёлын өөрчлөлт”, “Соёлын хожимдол” хэмээх ойлголтын тайлбар, жишээ болон бий болсон шалтгаан, үр дагаврын талаар дараах хүснэгтэд бичээрэй. Орон нутгийнхаа жишээгээр аль болох нотлож бичнэ үү.

	Соёлын өөрчлөлт	Соёлын хожимдол
Тайлбар		
Жишээ		
Бий болсон шалтгаан, үр дагавар		

Өөрийгөө үнэлээрэй.

“**Би хийж дууссан**” хэсэгт даалгавар бүрээс сайн ойлгосон, мэдсэн, чадсан, “**Би эргэлзэж байна**” хэсэгт дутуу хийсэн, “**Надад тусламж хэрэгтэй байна**” хэсэгт ойлгоогүй, дэмжлэг шаардлагатай даалгаврын харгалзах дугаарыг тус тус бичээрэй.

 Би хийж дууссан	 Би эргэлзэж байна	 Надад тусламж хэрэгтэй байна	 Багшийн үнэлгээ

8.3а. “Би орон нутгийнхаа түүх, соёлоор бахархдаг” сэдэвт соёлын өвийн танилцуулга сэтгүүлийн нүүр бэлтгээрэй. Дараах алхмын дагуу хийнэ үү.

Орон нутгийнхаа соёлын үнэт зүйлсийн жагсаалт гаргаарай.

- 1.
- 2.
- 3.
- 4.
- 5.

Соёлын үнэт зүйлсийнхээ өвөрмөц шинжийг тайлбарлан бичээрэй.

Танилцуулгыг бичихдээ уг соёлын өв ямар түүх өгүүлдэг, яагаад хайрлан хамгаалах, бахархах, өвлөх ёстой талаар мэдээлэл оруулаарай.

Тайлбар:

Тайлбар:



Тайлбар:

Орон нутгийнхаа соёлын дурсгалт газруудын байршлын зураглал хийгээрэй.

Зураглал:

Сургуулийнхаа сурагчдад зориулж, орон нутгийнхаа соёлын өвийг хэрхэн хайрлан хамгаалах, өвлөх талаар зөвлөмж бичээрэй.

8.3б. Орон нутгийнхаа соёлд хүндэтгэлтэй хандахаас гадна бусдын соёлд хүндэтгэлтэй хандахын учир, ач холбогдлыг илэрхийлсэн сонинд зориулсан товч нийтлэл бичнэ үү.



8.3в. Та өмнөх даалгавраар оюутан Б, З нарт тохиолдсон асуудалтай танилцаж, тохиолдолд дүн шинжилгээ хийсэн. Энэ удаад тэдний ангийнханд зориулсан асуудлыг хэрхэн зохистой шийдвэрлэх, бусдын орон нутгийн соёлд хэрхэн хүндэтгэлтэй хандах талаар санал боловсруулан бичээрэй.

8.3г. Орон нутагт бий болсон соёлын хожимдлыг арилгахад сурагч та ямар хувь нэмэр оруулж болох вэ? Мөн энэ талаар ямар зүйлийг манлайлан хийж, үе тэнгийнхэндээ үлгэр дуурайл үзүүлэх вэ? Доорх хүснэгтэд хариулж бичнэ үү.

Би дараах хувь нэмрийг оруулж чадна	Би дараах зүйлсийг манлайлан хийж чадна
<ul style="list-style-type: none"> ✓ ✓ ✓ ✓ 	<ul style="list-style-type: none"> ✓ ✓ ✓ ✓

Өөрийгөө үнэлээрэй.

“**Би хийж дууссан**” хэсэгт даалгавар бүрээс сайн ойлгосон, мэдсэн, чадсан, “**Би эргэлзэж байна**” хэсэгт дутуу хийсэн, “**Надад тусламж хэрэгтэй байна**” хэсэгт ойлгоогүй, дэмжлэг шаардлагатай даалгаврын харгалзах дугаарыг тус тус бичээрэй.

<p>Би хийж дууссан</p>	<p>Би эргэлзэж байна</p>	<p>Надад тусламж хэрэгтэй байна</p>	<p>Багшийн үнэлгээ</p>

8.2а. Орон нутгийн бизнесийн байгууллагуудаас нэгийг сонгож, дараах шинжилгээг хийнэ үү.

Эрхэлдэг үйл ажиллагаа:

а) Ямар нөөцүүдийг ашиглан, ямар бүтээгдэхүүн үйлдвэрлэдэг вэ?

б) Үйлдвэрлэлийн үйл ажиллагаанаас ямар төрлийн зардлууд гарахыг жагсаан бичээрэй.

--	--

в) Үйлдвэрлэлийн үйл ажиллагааны бүдүүвч зураглалыг хийгээрэй.

--

8.2б. Батын ах аймагтаа талхны цех ажиллуулдаг. Тэдний үйлдвэрийн 1 сарын орлого, зарлага, ашгийн тооцооллыг хийнэ үү.



Тус цех өдөрт 200 талх, 100 кг боов хийдэг. 1 талхны үнэ 1300 төгрөг, 1 кг боов 2300 төгрөг. Тэднийх нийт 3 ажилтантай бөгөөд тус бүр 1 сарын 600000 төгрөгний цалинтай. Түүхий эд материал худалдан авахад өдөрт 150000 төгрөг, түрээс болон бусад зардалд сард 3000000 төгрөг зарцуулдаг. Үүнээс татварын хуулийн дагуу олсон ашгийн 10%-ыг татварт төлдөг.

--

*Орлого:
Зарлага:
Ашиг:*

8.2в. “Эрэлт” ба “Нийлүүлэлт” ойлголтын ялгааг харьцуулан бичнэ үү.

8.2г. Эрэлт ба Нийлүүлэлтийн харьцаа нь яагаад зах зээлийн үнийг тодорхойлдог талаар тайлбар хийнэ үү.

8.3а. Өөрийн орон нутгийн аль нэг ААН-ийг сонгон аваарай.

➤ Үйлдвэрлэн гаргаж буй бүтээгдэхүүний нэр төрөл, үнэ, чанар зэрэгт үнэлэлт, дүгнэлт өгнө үү.

➤ Цаашид тус ААН бүтээгдэхүүн, үйлчилгээгээ сайжруулахын тулд юу хийх хэрэгтэй вэ? Шинэ санаа гаргаарай.

-
-
-
-

➤ Тухайн ААН орон нутагтаа ямар нөлөө үзүүлж байгаа вэ? Үнэлэн бичээрэй.

8.3б. Эрэлт болон нийлүүлэлтийн хуулийг мэдэх нь танд ямар ач холбогдолтой вэ? Түүнийг илэрхийлсэн агуулга, үйл явдал бүхий зурагт хуудас /комик/ хийгээрэй. Хийсэн зурагт хуудсаа энэ хуудсанд хавсаргаарай.

8.3в. Бүтээгдэхүүний зах зээл ба орон нутгийн төсвийн тухай ойлголтуудаар нийт 14 асуулт бүхий үгийн сүлжээ бүтээнэ үү. Бүтээсэн үгийн сүлжээгээ энэ хуудсанд хавсаргаарай.





8.3г. Орон нутагтаа жижиг бизнес эрхлэх төслийн санаа, зураглал боловсруулна уу.

Уг санаа, зураглалдаа дараах зүйлсийг тусгаарай: үйлдвэрлэх бараа, үйлчилгээний нэр төрөл, яагаад хүмүүст хэрэгтэй гэж үзэж байгаа, хэрхэн үйлдвэрлэх, үйлчилгээ үзүүлэх, ямар нөөц, хөрөнгө хэрэгтэй, хэрхэн олж авч ашиглах тухай тайлбар.

8.3д . Жижиг бизнес буюу үйлдвэрлэл эрхлэх төслийн санаа, зураглалаа хэрэгжүүлснээр олох 1 сарын орлого, зарлага, ашгийн хэмжээ, эрсдэлийг урьдчилан тооцоолж бичнэ үү.

Өөрийгөө үнэлээрэй.

“Би хийж дууссан” хэсэгт даалгавар бүрээс сайн ойлгосон, мэдсэн, чадсан, “Би эргэлзэж байна” хэсэгт дутуу хийсэн, “Надад тусламж хэрэгтэй байна” хэсэгт ойлгоогүй, дэмжлэг шаардлагатай даалгаврын харгалзах дугаарыг тус тус бичээрэй.

 <p>Би хийж дууссан</p>	 <p>Би эргэлзэж байна</p>	 <p>Надад тусламж хэрэгтэй байна</p>	 <p>Багшийн үнэлгээ</p>